



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2026/021/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2026 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: umnugovi@audit.gov.mn Азуре хүлүг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Г.Мөнхбаяр Утас: 70110090 Цахим хаяг: audit@azure.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16

№

325

танай

-ны №

-т

ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААН
ХАНГАМЖИЙН ГАЗАР ОНӨААТҮГ-
ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.МӨНХ-АМАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өмнөговь аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй "Нутгийн дэм" хөтөлбөрт хамрагдаж, байгууллагын албан хаагчдад нийт 145,079.2 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,345,361.8 мянган төгрөгийн дулааны шугам сүлжээний өргөтгөлийн ажил хийгдэж, тээврийн хэрэгсэл нийлүүлэгдсэн, сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 285,092.4 мянган төгрөгийн дулаан дамжуулах төвүүдийн барилгын засварын ажил хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус үйлдвэрийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгагдсан асуудал нь хамаарахгүй болно.

4626050484

Г.З.Биег хэрэглэн 2026 оны 03.16-нд хийсэн аудитын хураангуй тайлан

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	710,906,582.47	326,735,389.15
1.1.02	Дансны авлага	145,965,411.13	245,562,578.05
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	-	74,007,560.50
1.1.04	Бусад авлага	122,255.20	-
1.1.06	Бараа материал	98,201,417.66	94,410,616.78
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	955,195,666.46	740,716,144.48
1.2.01	Үндсэн хөрөнгө	25,719,596,883.40	26,193,968,844.73
1.2.02	Биет бус хөрөнгө	11,984,592.11	30,056,547.07
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	25,731,581,475.51	26,224,025,391.80
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	26,686,777,141.97	26,964,741,536.28
2.1.1.01	Дансны өглөг	193,665,701.14	194,363,369.46
2.1.1.03	Татварын өр	24,089,081.85	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	217,754,782.99	194,363,369.46
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	27,650,931,104.56	28,206,923,236.11
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	27,650,931,104.56	28,206,923,236.11
2.2	Өр төлбөрийн нийт дүн	27,868,685,887.55	28,401,286,605.57
2.3.02	- хувийн	320,008,928.00	320,008,928.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,575,351.99	15,575,351.99
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	6,226,000.00	29,326,000.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	(1,523,719,025.57)	(1,801,455,349.28)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(277,485,373.78)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(1,523,719,025.57)	(1,523,969,975.50)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(1,181,908,745.58)	(1,436,545,069.29)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	26,686,777,141.97	26,964,741,536.28

Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,053,439,134.38	3,859,536,916.29
2	Борлуулалтын өртөг	4,671,134,897.71	5,186,609,500.64
3	Нийт ашиг(алдагдал)	(617,695,763.33)	(1,327,072,584.35)
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	817,742,914.52	1,500,666,905.98
8.1	Орлогын дүн	817,742,914.52	1,500,666,905.98
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	291,858,763.79	447,777,137.23
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
12.1	Зардлын дүн	291,858,763.79	447,777,137.23
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	(3,302,558.18)
17.1	Олз, гарзын дүн	-	(3,302,558.18)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(91,811,612.60)	(277,485,373.78)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(91,811,612.60)	(277,485,373.78)
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(91,811,612.60)	(277,485,373.78)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
24	Орлогын нийт дүн	-	-
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	320,008,928.00	15,575,351.99	6,226,000.00	(1,431,907,412.97)	(1,090,097,132.98)
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	-	-	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(91,811,612.60)	(91,811,612.60)
2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	320,008,928.00	15,575,351.99	6,226,000.00	(1,523,719,025.57)	(1,181,908,745.58)
НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(250,949.93)	(250,949.90)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(277,485,373.78)	(277,485,373.78)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	23,100,000.00	-	23,100,000.00
2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	320,008,928.00	15,575,351.99	29,326,000.00	(1,801,455,349.28)	(1,436,545,069.29)

Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,325,181,478.41	4,596,220,102.80
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,735,707,906.90	4,070,006,958.48
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,589,473,571.51	526,213,144.32
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,169,147,937.35	4,947,775,846.12
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,131,833,781.82	1,417,257,713.67
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	342,503,734.08	425,587,183.55
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	642,314,475.00	736,692,137.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,363,919,133.35	1,557,776,928.74
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	170,462,590.03	159,182,201.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	347,375,373.28	425,789,395.38
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	382,860.00	1,314,065.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	170,355,989.79	224,176,221.78
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	156,033,541.06	(351,555,743.32)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.8	Бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,805,000.00	32,615,450.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,805,000.00	32,615,450.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.2.6	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,805,000.00)	(32,615,450.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.1.4	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.5	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	153,228,541.06	(384,171,193.32)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	557,678,041.41	710,906,582.47
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	710,906,582.47	326,735,389.15

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

д/д	Зардлын нэр	2025 он төлөвлөгөө	2025 он гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Ашиглалтын зардал	4,365,368.7	1,521,117.4	(2,844,251.4)	34.8
1	ДЭХ-ний зардал	4,141,275.3	1,296,066.0	(2,845,209.3)	31.3

Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

2	ДЭХ оффис	6,769.1	4,393.8	(2,375.4)	64.9
3	Цэвэр ус	2,140.3	2,976.9	836.6	139.1
4	Нэмэлт ус	10,611.7	18,796.4	8,184.7	177.1
5	Цахилгааны зардал	204,572.4	198,884.3	(5,688.1)	97.2
	Цалин	2,182,801.6	1,754,470.2	(428,331.4)	80.4
6	Үндсэн цалин	929,991.7	705,721.7	(224,270.0)	75.9
7	УЖНэмэгдэл	174,892.2	117,931.9	(56,960.3)	67.4
8	Сарын үр дүн	197,119.1	160,484.2	(36,634.9)	81.4
9	Хоолны хөнгөлөлт	123,492.0	85,728.0	(37,764.0)	69.4
10	ЭХТА	1,440.0	1,095.0	(345.0)	76.0
11	Хавсран	4,338.7	16,005.5	11,666.8	368.9
12	ЭА	154,878.4	134,237.1	(20,641.3)	86.7
13	Шөнийн цаг	110,724.2	105,814.8	(4,909.4)	95.6
14	амралт баяр ёслол	8,520.5	14,881.3	6,360.8	174.7
15	Илүү цаг	25,235.8	26,303.8	1,068.0	104.2
16	Нутгийн дэм	196,800.0	127,597.9	(69,202.1)	64.8
17	ТУЗ-н цалин	42,108.0	45,408.0	3,300.0	107.8
18	ЖУДШагнал	213,261.0	213,261.0	0.0	100.0
	НДШимтгэл	310,400.6	242,283.8	(68,116.8)	78.1
19	НДШимтгэл	310,400.6	242,283.8	(68,116.8)	78.1
	Бусад	650,809.2	484,986.7	(165,822.5)	74.5
20	Засварын зардал	196,930.5	196,793.9	(136.6)	99.9
21	Аваарын нөөц	9,627.5	9,627.5	-	100.0
22	Томилолтын зардал	51,840.0	4,764.0	(47,076.0)	9.2
23	Механизмын зардал	88,034.0	66,315.7	(21,718.3)	75.3
24	Тээврийн зардал	10,500.0	16,017.3	5,517.3	152.5
25	Цэвэрлэгээний зардал	1,652.8	1,073.0	(579.8)	64.9
26	ТУЗ зардал	43,608.0	45,166.1	1,558.1	103.6
27	Бичиг хэргийн зардал	17,514.0	14,107.6	(3,406.4)	80.6
28	ХХАА-ны зардал	43,684.4	32,571.6	(11,112.8)	74.6
29	Галын аюулаас хамгаалах	1,650.0		(1,650.0)	-
30	Гамшигаас хамгаалах	13,635.0		(13,635.0)	-
31	Байгаль орчин	733.0	733.0	-	100.0
32	Зар сурталчилгааны зардал	15,920.0	12,677.8	(3,242.2)	79.6
33	Шуудан холбооны зардал	31,334.5	6,292.8	(25,041.7)	20.1
34	Даатгал /Техник хэрэгсэл/	7,243.0	1,338.8	(5,904.2)	18.5
35	Шатахууны зардал	116,902.5	77,507.7	(39,394.8)	66.3
	Аж/нийгэм зардал	114,550.3	87,214.8	(27,335.5)	76.1
36	баяр ёслол, биеийн тамир	5,400.0	3,967.2	(1,432.8)	73.5
37	Шагнал	2,600.0		(2,600.0)	-
38	Түлшний хөнгөлөлт	6,800.0		(6,800.0)	-
39	Ахмадын зардал	6,400.0	5,771.7	(628.3)	90.2
40	Тэтгэмж, тусламж	45,321.7	41,275.2	(4,046.6)	91.1
41	Сургалтын зардал	43,028.6	33,555.0	(9,473.6)	78.0
42	Бусад зардал	5,000.0	2,645.8	(2,354.2)	52.9
	Хөрөнгийн зардал	90,634.0	25,880.1	(64,753.9)	28.6
1	Тоног төхөөрөмж	90,634.0	25,880.1	(64,753.9)	28.6
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,714,564.4	4,115,953.0	(3,598,611.4)	53.4
1	Борлуулалтын орлого	7,081,921.8	3,859,536.9	(3,222,384.9)	54.5
	ҮА-НЫ ОРЛОГЫН ДҮН	7,081,921.8	3,859,536.9	(3,222,384.9)	54.5
1	Үйл ажиллагааны бус орлого	725,100.2	298,644.9	(426,455.3)	41.2
2	Нутгийн дэм	208,800.0	145,079.2	(63,720.8)	69.5
	ҮА-НЫ БУС ОРЛОГЫН ДҮН	933,900.2	443,724.0	(490,176.1)	47.5
1	Үйл ажиллагааны бус зардал	288,790.0	309,203.6	20,413.6	107.1
	ҮА-НЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	288,790.0	309,203.6	20,413.6	107.1
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	8,015,822.0	4,303,261.0	(3,712,561.0)	53.7
	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	8,003,354.4	4,425,156.6	(3,578,197.8)	55.3
	Ашиг /+/, Алдагдал /-/	12,467.5	(121,895.7)	(134,363.2)	(977.7)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 287.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад 287.1 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

- 2025 оны "Санхүүгийн байдлын тайлан"-ийн эхний үлдэгдэл 2024 оны аудит хийсэн санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй;
- "Санхүүгийн байдлын тайлан" болон бараа материалын тайлангийн тодруулгад хангамжийн материал, багаж хэрэгслийн материалын үлдэгдлийг 1.8 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн;
- Даланзадгадын сумын Засаг даргын 2025 оны А/187 дугаар захирамж 285.1 сая төгрөгийн дулаан дамжуулах төвийн барилгын засварын ажлыг хөрөнгөнд бүртгээгүй байна.

Аудитаар 68.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 49.6 сая төгрөгийн 4 албан шаардлага, 18.5 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6.3 сая төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

1.Тайлант хугацаанд 11.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал, сургалтын төлбөрийн зардлыг гаргах тушаалд Гүйцэтгэх захирал өөрийн нэрийг оруулсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийн хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэх, зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2.Спортын тэмцээн, уралдааны зардалд 3.0 сая төгрөгийн ажил гүйлгээ гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэж заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Сургалт, туршлага судлах зардалд 35.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 4.2.2-т "хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.Өмнөх аудитаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуульд заасан шууд худалдан авалт хийх төсөвт өртгийн дээд хязгаараас давсан шууд худалдан авалт хийсэн" зөрчилд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д "Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно", 10.12-т "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоол "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" журамд "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар 20 сая төгрөг", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын 19.2 дахь заалт "шалгаагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх, зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын түлш, шатах тослох материалын зарцуулалтыг тулган шалгахад жолоочийн тооцооны хуудсанд ирсэн явсан цаг, спидометрийн эхний, эцсийн заалтыг, явсан километр болон зарцуулсан шатахууны мэдээлэл, хаашаа явсан мэдээллийг бүрэн бөглөөгүй, санхүүгийн тэмдэг, гарын үсгээр баталгаажуулаагүй, мөн бараа материалын зарлагын ажил гүйлгээний шаардах хуудсанд зөвшөөрсөн, олгосон тоо хэмжээ байхгүй, санхүүгийн тэмдэг, гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасныг хэрэгжүүлээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын анхан шатны баримтын бүрдлийг хангаж, дотоод хяналтыг сайжруулах;

2. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Мөнгөн зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад баримт бүрдэл дутуу 18.5 сая төгрөгийн ажил гүйлгээ бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх, 20.1.1. нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт

Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;" гэж заасныг хэрэгжүүлээгүй, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Мөнгөн хөрөнгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж, дотоод хяналтыг сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй Орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2025 оны "Санхүүгийн байдлын тайлан"-ийн эхний үлдэгдэл 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс 250.9 мянган төгрөгөөр зөрүүтэй.	1	250.9	-	-	1	250.9	-	-	-	-	-	-
2	"Санхүүгийн байдлын тайлан" болон бараа материалын тайлангийн тодруулгад хангамжийн материал, багаж хэрэгслийн материалын үлдэгдлийг 1,779.1 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн	1	1,779.1	-	-	1	1,779.1	-	-	-	-	-	-
3	Даланзадгадын сумын Засаг даргын 2025 оны А/187 дугаар захирамж 285,092.4 мянган төгрөгийн ДДТөвүүдийн барилгын засварын ажлыг хөрөнгөнд бүртгээгүй.	1	285,092.4	1	285,092.4	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	1	287,122.4	1	285,092.4	-	2,030.0	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Мөнгөн зарлагын ажил гүйлгээг анхан шатны баримт руу тулган шалгахад баримт бүрдэл дутуу 18,475.5 мянган төгрөгийн ажил гүйлгээ бүртгэлд тусгасан.	1	18,475.5	-	-	-	-	1	18,475.5	-	-	-	-
2	Бараа материалын түлш, шатах тослох материалын зарцуулалтыг тулган шалгахад жолоочийн тооцооны хуудсанд ирсэн явсан цаг, спидометрийн эхний, эцсийн заалтыг, явсан километр болон	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

Даланзадгадын дулаан хангамжийн газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

	зарцуулсан шатахууны мэдээлэл, хаашаа явсан мэдээллийг бүрэн бөглөөгүй, санхүүгийн тэмдэг, гарын үсгээр баталгаажуулаагүй, мөн бараа материалын зарлагын ажил гүйлгээний шаардах хуудсанд зөвшөөрсөн, олгосон тоо хэмжээ байхгүй, санхүүгийн тэмдэг, гарын үсгээр баталгаажуулаагүй.												
3	Тайлант хугацаанд 11,315.7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал, сургалтын төлбөрийн зардлыг гаргах тушаалд Гүйцэтгэх захирал өөрийн нэрийг оруулсан.	1	11,315.7	-	-	1	11,315.7	-	-	-	-	-	-
4	Спортын тэмцээн, уралдааны зардалд 3,000.0 мянган төгрөгийн ажил гүйлгээ гаргасан.	1	3,000.0	-	-	1	3,000.0	-	-	-	-	-	-
5	Тайлант хугацаанд сургалт, туршлага судлах зорилгоор 35,310.0 мянган төгрөгийн зардал гаргасан.	1	35,310.0	-	-	1	35,310.0	-	-	-	-	-	-
6	Өмнөх аудитаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хуульд заасан шууд худалдан авалт хийх төсөвт өртгийн дээд хязгаараас давсан шууд худалдан авалт хийсэн" зөрчилд өгсөн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-
	Дүн	6	68,101.2	-	-	4	49,625.7	2	18,475.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, хууль, тогтоомжууд шинэчлэгдэж байгаа бөгөөд 2015 оны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үндэслэн санхүүгийн бүртгэл хөтөлж, тайлан бэлтгэсэн.	1	-	-	-	-	-	1	-
	Дүн	1	-	-	-	-	-	1	-